



## МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ХООРОНД ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид "Талууд" гэнэ)

Эрх чөлөөгөө хязгаарлуулан хорих ялаар шийтгэгдсэн ялтныг харъяалах улсад нь шилжүүлэн ялыг нь эдлүүлэх, тэдгээрийг нийгэмших явцад туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор Талууд хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй байгааг харгалзан,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү гэрээний зорилгоор:

- (a) "Шилжүүлэгч Тал" гэдэгт ялтныг шилжүүлэн өгч байгаа Талыг хэлнэ;
- (b) "Хүлээн авагч Тал" гэдэгт ялтныг шилжүүлэн авч байгаа Талыг хэлнэ;
- (c) "Ял" гэдэгт эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхээс хугацаатай болон тодорхой хугацаагүйгээр эрх чөлөөг хасч шийтгэсэн шийтгэлийг хэлнэ;
- (d) "Ялтан" гэж Шилжүүлэгч Талын хэргийн харъяалалын дагуу шүүхээс ял шийтгэлээр шийтгэгдсэн этгээдийг хэлнэ;
- (e) "Иргэн" гэдэгт Шилжүүлэгч Тал болон Хүлээн авагч Талын иргэний харъяалалтай иргэнийг хэлнэ.

### ХОЁРДУГААР ЗҮЙЛ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1. Талууд энэхүү Гэрээний заалтын дагуу ялтныг шилжүүлэх чиглэлээр харилцан хамтын ажиллагааны арга хэмжээг өргөн хүрээнд авна.
2. Энэхүү Гэрээний дагуу ялтныг Шилжүүлэгч Талын харъяалалаас Хүлээн авагч Талын харъяалалд Шилжүүлэгч Талаас оногдуулсан ял шийтгэлийг эдлүүлэхээр шилжүүлэн өгч болно.
3. Ялтныг шилжүүлэх хүсэлтийг Шилжүүлэгч Тал болон Хүлээн авагч Талын аль аль нь гаргаж болно.



## ГУРАВДУГААР ЗҮЙЛ ЭРХ БҮХИЙ ТӨВ БАЙГУУЛЛАГА

1. Энэхүү Гэрээний заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Талууд эрх бүхий байгууллагыг томилно.
2. Монгол Улсын эрх бүхий төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх бүхий төв байгууллага нь Хууль зүйн яам байна. Талууд эрх бүхий төв байгууллагыг өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд нөгөө талдаа мэдэгдэнэ.
3. Талууд яаралтай эсхүл онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд дипломат шугамаар харилцана.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ

1. Ялтныг зөвхөн дараах нөхцөлд шилжүүлнэ. Үүнд:

(a) Тухайн Ялтны ял хүлээсэн үйлдэл нь Хүлээн авагч Талын хуулиар гэмт хэрэгт тооцогдож, ял ногдуулж болохоор байх. Энэ уггаараа тухайн гэмт үйлдлийн үндсэн шинжид үл хамаарах нөхцөл байдал нь уг гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял шийтгэл ногдуулахад нөлөөлөхгүй;

(b) Хүлээн авагч Тал нь Бүгд Найрамдах Солонгос Улс байвал ялтан нь БНСУ-ын иргэн байна;

(c) Хүлээн авагч Тал нь Монгол Улс байвал ялтан нь Монгол Улсын иргэн байна;

(d) Шилжүүлэн авах тухай хүсэлт гаргах үед ялтан нь нэгээс доошгүй жил эдлэх ялтай эсхүл хугацаагүй болон насаараа хоригдох ялтай байна;

(e) Шүүхийн таслан шийдвэрлэгдэх тогтоол эцэслэн гарсан байх ба Шилжүүлэгч талын байцаан шийтгэх ажиллагаа бүрэн дууссан байна;

(f) Шилжүүлэгч болон Хүлээн авагч Талууд ялтныг шилжүүлэхийг харилцан зөвшөөрөх ба Талууд шаардлагатай гэж үзвэл ялтны нас, биеийн болон оюун санааны нөхцөл байдлыг харгалзан үзнэ;

(g) Ялтан болон түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг баталгаажуулсан байна.

2. Онцгой тохиолдолд Талууд энэхүү зүйлийн 1 (d) хэсэгт зааснаас богино хугацааны ял эдлэхээр байгаа ялтныг шилжүүлж болно.



## **ТАВДУГААР ЗҮЙЛ ЗӨВШӨӨРЛИЙГ НОТЛОХ НЬ**

1. Талууд 4 дүгээр зүйлийн 1 (г) хэсэгт заасны дагуу шилжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн этгээдийг шийдвэр гаргахдаа сайн дураар, үүсэх нөхцөл байдлын талаар бүрэн ойлголттой байсан эсэхийг хянан үзнэ.

2. Шилжүүлэгч Тал нь 4 дүгээр зүйлийн 1 (г) хэсэгт заасны дагуу сайн дурын үндсэн дээр, үүсэх нөхцөл байдлын талаар бүрэн ойлголттой гэдгээ өөрөө нотолж шилжүүлэхийг хүссэн ялтаны зөвшөөрлийг баталгаажуулах зорилгоор Хүлээн авагч Талын эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэхээс өмнө зөвшөөрөл олгоно.

## **ЗУРГААДУГААР ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭГЧ ТАЛЫН ҮР НӨЛӨӨ**

1. Хүлээн авагч Талын эрх бүхий этгээд ялтныг хүлээж авснаар Шилжүүлэгч Талын ял эдлүүлэх ажиллагаа дуусгавар болно.

2. Хэрэв Хүлээн авагч Тал нь ял эдлүүлэх ажиллагаа дуусгавар болсон гэж үзвэл Шилжүүлэгч Тал ял эдлүүлэхийг шаардахгүй.

## **ДОЛДУГААР ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ**

1. Талууд ялтанд энэхүү Гэрээний дагуу шилжүүлэх эрхийг мэдэгдэнэ.

2. Хэрэв Ялтан шилжүүлэхийг өөрөө хүсвэл хүсэлтээ аль нэг талд гаргах ба Хүсэлт хүлээн авсан Тал нь бичгээр нөгөө талдаа мэдэгдэнэ.

3. Шилжүүлэх хүсэлтийг Хүлээн авагч Тал эсхүл Шилжүүлэгч Тал нь нөгөө талдаа гаргана. Хүсэлт хүлээн авагч Тал нь нөгөө талдаа хүсэлтийг хүлээн авч байгаа эсэх талаар даруй мэдэгдэнэ.

4. Шилжүүлэх хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд хүсэлтэд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- a) Ялтаны нэр, төрсөн газар, огноо
- b) Ялтаны харъяалалын байдлыг тодорхойлсон баримт бичиг
- c) Ялтаны байрлаж байгаа газар болон оршин байгаа газрын хаяг

5. Шилжүүлэх хүсэлтийг гаргасан үед Шилжүүлэгч Тал нь Хүлээн авагч Талд дараах мэдээллийг бичгээр өгнө. Үүнд:

(a) Гэм буруутайд тооцож ял оногдуулсан тухай баримт бичгийн мэдэгдэл;

(b) Шилжүүлэгч Талаас гэм буруутайг тооцож ял оногдуулахдаа үндэслэсэн заалт бүхий холбогдох хуулийн хуулбар;

(c) Ялын төрөл, үргэлжлэх хугацаа, дуусгавар болох өдөр, боломжтой тохиолдолд ялтны биеэр эдэлсэн ялын хугацаа, ажил хийсэн, хүмүүжиж



байгаа байдалд олгосон шагналын хоног, цагдан хоригдсон хугацаа, болон хасагдсан хугацааны талаарх өөр бусад мэдээлэл;

(d) Гэм буруутайд тооцон ял оногдуулсан баримт бичгийн хуулбар.

6. Аль нэг Тал нь шилжүүлэх хүсэлт гаргах эсхүл шилжүүлэх хүсэлтийг хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргахаас өмнө мэдээлэл, баримт материалыг өгөхийг хүсвэл нөгөө талдаа гаргаж өгнө. Энэ тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Тал нь 8 (3) зүйлтэй ялыг нийцүүлэх эсэх талаар Шилжүүлэгч Талд мэдэгдэнэ.

7. Шилжүүлэгч Талын хуулийн дагуу Талууд харилцан тохиролцсон газар, өдөр Шилжүүлэгч Талын эрх бүхий этгээдээс Хүлээн авагч Талын этгээдэд ялтныг хүлээлгэж өгнө.

8. Талууд ялтан этгээдэд энэхүү зүйлийн заалтын дагуу Шилжүүлэгч Тал болон Хүлээн авагч Талаас авсан арга хэмжээний талаархи мэдээллийг бичгээр гаргаж өгнө.

### **НАЙМДУГААР ЗҮЙЛ ЯЛ ШИЙТГЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ЭДЛҮҮЛЭХ**

1. Хүлээн авагч Тал нь энэхүү зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлийн дагуу ялыг өөрийн орны хуультай нийцүүлэн ялыг эдлүүлнэ.

2. Шилжүүлсний дараа ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх ажиллагааг Хүлээн авагч Талын хууль журмаар зохицуулна. Тухайлбал, ял эдлүүлэх дэглэм, эрх чөлөөг хязгаарлах хэлбэр, ял эдлэх хугацааг багасгах, хугацаанаас нь өмнө суллах, нөхцөлтэйгээр суллах.

3. Хэрэв Хүлээн авагч Талын хуультай оногдуулсан ялын төрөл, хугацаа нь нийцэхгүй байвал Хүлээн авагч Тал нь ялыг өөрийн дотоодын хуульд заасан ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг ял шийтгэлтэй нийцүүлэн өөрчилж болно. Ял шийтгэлийг өөрчлөхдөө Хүлээн авагч Талын эрх бүхий этгээд Шилжүүлэгч Талын гэм буруутайд тооцсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, оногдуулсан ял зэрэг цуглуулсан нотлох баримт дээр тулгуурлаж шийдвэрээ гаргана. Өөрчилсөн ял нь Шилжүүлэгч Талын оногдуулсан ялын хугацаа, төрлөөс хүнд байж болохгүй. Хүлээн авагч Талын эрх бүхий этгээд ялыг өөрчлөхдөө биеэр эдлэх ял шийтгэлийг төлбөр төлөх хэлбэрээр өөрчилж болохгүй.

4. Хүлээн авагч Тал нь Шилжүүлэгч Талаас тухайн ялтныг өршөөсөн эсхүл ялыг бууруулсан буюу чөлөөлсөн тухай шийдвэрийг хүлээн авсан даруй ял эдлүүлэх ажиллагааг өөрчлөх буюу дуусгавар болгоно.

5. Хүлээн авагч Тал нь Шилжүүлэгч Тал хүсэлт гаргавал ял эдлүүлэхтэй холбогдсон мэдээллийг гаргаж өгнө. Аль ч Тал нь хэдийд ч аливаа ял эдлүүлэх ажиллагааны талаарх тусгай мэдээллийг хүсч болно.



## **ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ХЭВЭЭР ХАДГАЛАГДАХ**

Шилжүүлэгч Талд шүүхээс гэм буруутайд тооцож, ял оногдуулах ажиллагааг хянан шийдвэрлэх давуу эрх нь хадгалагдана.

## **АРАВДУГААР ЗҮЙЛ ЯЛТНЫГ ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ**

Хэрэв Талуудын аль нэг нь ялтныг шилжүүлэхэд нөгөө Тал нь өөрийн нутаг дэвсгэр дээр дамжин өнгөрүүлэх ажиллагааг хялбаршуулах журмаар хамтран ажиллана. Шилжүүлэх арга хэмжээ авч байгаа Тал нь нөгөө талдаа дамжин өнгөрүүлэх талаарх мэдээллийг урьдчилж хүргүүлнэ.

## **АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ХАРИЛЦАХ ХЭЛ БОЛОН ЗАРДАЛ**

1. Талууд ялтныг шилжүүлэх тухай хүсэлтийг Шилжүүлэгч Талын эх хэл дээр эсхүл англи хэл дээр баталгаажуулсан орчуулгатай хавсаргаж бичгээр нөгөө талдаа хүргүүлнэ.

2. Шилжүүлэх ажиллагаатай холбогдон гарах аливаа зардлыг ялтан этгээд хариуцана. Хэрэв Хүлээн авагч Тал нь ялтны нэрийн өмнөөс зардлыг төлсөн тохиолдолд дотоодын хууль тогтоомжийн дагуу ялтнаас шилжүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг бүхлээр нь болон хэсэгчлэн төлүүлж болно. Шилжүүлэн авсны дараа ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхтэй холбогдон гарах аливаа зардлыг Хүлээн авагч Тал хариуцана.

## **АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлах, үйлчлэх хүрээтэй холбогдон үүссэн аливаа маргааныг төв байгууллагууд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

## **АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ**

Энэхүү Гэрээ нь гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө болон хүчин төгөлдөр болсноос хойш ял авсан ялтан этгээдийг шилжүүлэхэд хамаарна.

## **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ БУСАД ХЭЛЭЛЦЭЭРҮҮД**

Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд бусад гэрээ хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүрэг эсхүл бусад гэрээ хэлэлцээрийн дагуу харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүссэн үүрэгт хамаарахгүй.



## АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

1. Энэхүү Гэрээг соёрхон батлана. Талууд соёрхон баталсан батламж жуух бичгийг Улаанбаатар хотноо солилцоно. Энэхүү Гэрээ нь батламж жуух бичиг солилцоноос хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Талуудын аль нэг нь энэхүү Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтийг дипломат шугамаар нөгөө Талдаа бичгээр гаргаснаар дуусгавар болгож болно. Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 180 дахь хоног дээр дуусгавар болно. Гэрээ дуусгавар болохоос өмнө эхэлсэн шилжүүлэх ажиллагаанд гэрээний дуусгавар болох хугацаа хамаарахгүй.

3. Энэхүү Гэрээ нь хүчин төгөлдөр болохоос өмнөх хэрэгт Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа гаргасан хүсэлтэд хамаарна.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ: Талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг 2007 оны 5 дугаар сарын 28 -ны өдөр Сөүл хотноо монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС  
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ